

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2023.09.04	A/461	Хөрөнгө зарцуулах тухай	
2	Аймгийн Засаг дарга	2023.09.18	A/485	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2023.09.26	A/492	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: **Б.Гантулга**



Холбогдох утас: 70384096, 88089938
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/461

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Их хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дүгээр тушаал, 2023 оны "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/399 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөн, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд "Органик Хөвсгөл-Органик мах" арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 29,000,000 (Хорин есөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 29,000,000 (Хорин есөн сая) төгрөгийг "Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал"-аас гаргаж, Хүнс, хөдөө аж ахуйн газрын нэмэлт дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд, удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар), аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар АУ/85

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XX хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөлд зочлох жил нэрлэсэн жилийн хүрээнд “Аи Ти Эм олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн”-д түнш аймгаар оролцох төлбөр 22.000.000 (Хорин хоёр сая) төгрөгийг Монголын аялал жуулчлалын холбоонд, үзэсгэлэнд оролцох бусад зардалд 8.000.000 (найман сая) төгрөг, нийт 30.000.000 (гучин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 30.000.000 (Гучин сая) төгрөгийг Засаг дарга дансны “Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. “Ай Ти Эм олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн”-д аймаг орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар) -д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/402

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн суманд ашиглагдаж байгаа хяналтын камерын эрчим хүчний 2023 хагас жилийн төлбөрт 1,683,334 (Нэг сая зургаан зуун наян гурван мянга гурван зуун гучин дөрвөн) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 1,683,334 (Нэг сая зургаан зуун наян гурван мянга гурван зуун гучин дөрвөн) төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд батлагдсан "Гудамжны хяналтын камерын кабелийн худаг, сувагчлал, агаарын баганын түрээс, цахилгааны төлбөрийн зардал"-аас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа А.Алтанцоож)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ